



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн балансын үнэ, 8,502,281.07(найман сая таван зуун хоёр мянга хоёр зуун наян нэгэн төгрөг долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Б.Мөнхдалай, Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежийн захирал Д.Баярмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133000356
6-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны... дугаар сарын... дөдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Хьюндай Старекс суудлын автомашин, арлын дугаар /KMJWAN7JP9U150941/ улсын дугаар 56-05 ХОУ	2009	1	20,000,000.00	8,502,281.07	11,497,718.93
	Нийт дүн		1	20,000,000.00 (хорин сая)	8,502,281.07 (найман сая таван зуун хоёр мянга хоёр зуун наян нэгэн төгрөг долоон мөнгө)	11,497,718.93 (арван нэгэн сая дөрвөн зуун ерэн долоон мянга долоон зуун арван найман төгрөг ерэн гурван мөнгө)